



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/447

Улаанбаатар хот

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.НҮБ-ийн Хүүхдийн сангийн хандивласан нийт 89,100,000.00 (наян есөн сая нэг зуун мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Б.Амгаланбаяр)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Б.Амгаланбаяр)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 114 дугаар тушаалын хавсралт

Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Зоонозын өвчин судлалын үндэсний төв

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Бүртгэлийн анхны үнэ /төгрөгөөр/		Хөрөнгө оруулалтын шийдвэр болон хандивлагчийн нэр	Хөрөнгийн эх үүсвэр
						нэгжийн үнэ	нийт дүн		
1	Зөөврийн батарей	ECOFLOW	2024		ш	6,000,000.00	60,000,000.00	Хандив	
2	Зөөврийн батарей	ECOFLOW	2024		ш	2,000,000.00	6,000,000.00	Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сан	Хандив
3	Панел	ECOFLOW	2024		ш	1,300,000.00	3,900,000.00		Хандив
4	Старлинк	GEN3	2024		ш	9,600,000.00	19,200,000.00		Хандив
Машин тоног төхөөрөмжийн дүн							89,100,000.00		
НИЙТ ДҮН							89,100,000.00		